

ИХ СУРГУУЛИУДЫН САНХҮҮГИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Д.Эрдэнэжаргал¹, Я.Батцэцэг², Я.Уранзул¹, Ц.Ганбаатар³
 ШУТИС, ДаТС магистр¹, ШУТИС, ДаТС², ХААИС, АБС³
 erka_10d@stda.edu.mn, Battsetseg.ya@stda.edu.mn,
 tsgan_baa@yahoo.com

Үндэслэл, шаардлага:

Дээд боловсрол нь нийгэмд жендэрийн тэгш байдал, тэгш эрхийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийгмийн жендэрийн харилцааны төлөв байдлын тусгал байх бөгөөд энэхүү төлөв байдлаас жендэрийн тэгш байдал, тэгш эрхийг тогтооход ямар хувь нэмэр оруулах вэ? гэдэг нь хамаарч байдаг юм. Дээд боловсрол нь бүх нийтэд нээлттэй, тэгш хүртээмжтэй байснаар хүмүүсийн нийгмийн давхрагын байр сууриа өөрчлөх боломжийг олгон, нийгэм дэх тэгш бус байдлыг бууруулах гарц болдог. Боловсролын тэгш бус байдал нь хүртээмжтэй байгаа эсэхэд 2015 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн 70 дугаар чуулганаар баталсан “Эх дэлхий өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030”-ийн зорилт 4-т боловсролын тэгш байдлыг хангах, зорилт 5-д жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн зорилтуудыг дэвшүүлсэн байдаг.

Дээд боловсрол дахь жендэрийн тэнцвэртэй байдалд эрэгтэй, эмэгтэй оюутнуудын тоон харьцаа, боловсрол эзэмшиж буй суралцагчдын төлөөллийн оролцоо тэгш хангагдах, жендэрийн тэнцвэртэй хангах асуудлыг тодорхойлох болон жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг төлөвлөх нь зайлшгүй шаардлага урган гарч байна. Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд хийж буй төгсөгчдийн мөшгөх судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг элсэлтийн хяналтын тоотой уялдуулах бодлогын зохицуулалт өнөөдөр хангалтгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Жендэрийн тэгш бус байдлыг тодорхойлох индекс нь онолын хувьд эрэгтэй оюутанд ноогдох эмэгтэйчүүдийн харьцааны үзүүлэлтийг харуулах бөгөөд харьцааны үзүүлэлт 0.97-1.03 байвал жендэрийн тэнцвэртэй байдалд хүрсэн гэж үздэг тул их дээд сургуулиуд сургалт, судалгааны үйл ажиллагааг зохион байгуулахдаа жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт хийх асуудал өдөр тутам тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. Дээд боловсрол дахь жендэрийн тэгш байдлыг хангах үйл хэрэг нь их, дээд сургууль төдийгүй үндэсний хэмжээний бодлого, эрх зүйн таатай орчин бүрдүүлж байж хангагдах юм. Бодлого, хууль эрх зүйн хувьд нийгмийн амьдралын тодорхой түвшинд оршин байгаа нөхцөл байдлыг хадгалах

хийгээд өөрчлөх шаардлага урган гарч байна.

Судалгааны ажлын зорилго:

Дээд боловсролын сургалтын байгууллагуудын элсэлтийн өнөөгийн байдал, элсэгчдийн, профессор багш нарын жендэрийн тэнцвэртэй байдлыг хангахад тулгарч буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх боломж нөхцөлийг тодруулан, санал зөвлөмж гаргах, төсвийн төлөвлөлтөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн тэгш байдлыг тогтооход нөлөөлөхүйц эерэг төсөв төсөвлөсөн эсэхийг тодруулах, жендэрийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг дэмжсэн үйл ажиллагааг хөгжүүлэх жендэрийн мэдрэмжтэй төсвийн зөвлөмжийг боловсруулахад судалгааны ажлын зорилго оршино. Зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ.

1. Жендэрийн дүн шинжилгээ, статистик мэдээлэлд суурилсан бодлого төлөвлөлт, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг Их дээд сургуулийн төвшинд хөгжүүлэх нөхцөл боломж, нөлөөллийн судалгаа хийх;

2. Жендэрийн тэгш байдлыг хангах сургалт, судалгааны тогтолцоо хөгжиж, механизм боловсронгуй болгох арга замыг тодорхойлох.

3. ДаТС-ийн профессор, багш нарын өөрийн үнэлгээнд судалгаа хийж жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн санал зөвлөмжийг боловсрууллаа.

Судалгааны ажлын онол, арга зүйн үндэс:

Жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалд суурилан төсвийн төлөвлөлтөд нийтлэг хэрэглэгддэг зүйл-заалтын төсөв, гүйцэтгэлд суурилсан төсөв, хөтөлбөрт төсөв, төлөвлөгөө-хөтөлбөр-төсвийн тогтолцоо, тэг суурьт төсөв, тэнцвэрт төсөв, математик статистик, эконометрикийн тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан ашигласан. (баримт бичгийн судалгаа, асуулгын)

Судлагдсан байдал:

Монгол улсын ДБСБ-ийн суралцагчдын хүйсийн харьцаа, жендэрийн урвуу үзүүлэлттэй байгааг Overseas Development Institute ODI)-nay 2015 оны кейс судалгаа, Дэлхийн банкны 2013 оны судалгааны тайлан зэрэг загвар ашиглан судалгааны ажлын зорилгын хүрээнд бий

болсон тулд энэ чиглэлийн судалгааны ажлууд манайд цөөнгүй хийгдсэн байдаг. Тухайлбал, Н.Бадмаа, Р.Чанцалдулам, Б.Одгэрэл, Ц.Одгэрэл, О.Оюунтунгалаг нарын судалгааны ажлын тайланг дурдаж болох юм.

Хүлээгдэж буй үр дүн:

1. Нотолгоонд суурилсан бодлогын зөвлөмжийг боловсруулах
2. Үр дүнд суурилсан жендэрийн мэдрэмжтэй бодлогын төсөвлөлтийг тодорхойлох

Оршил

Боловсрол бол хувь хүний нийгмийн амьдралд оролцох, амьдралынхаа чанар, төвшинг дээшлүүлэх боломжийг бүрдүүлж, сонголтын хүрээгээ өргөжүүлэх суурь нөхцөл болдог. Иймд хөгжил бол хувь хүн аливаа асуудалд мэдлэгт тулгуурлан хандах, урт удаан, эрүүл саруул амьдрах, өөрийн амьдралын хэрэгцээнд шаардлагатай нөөц, эх үүсвэрт хүрэлцээтэй байх, нийгэм, олон нийтийн үйл хэрэгт чөлөөтэй оролцох чадамжийг бий болгохын төлөө чиглэгдэх ёстой. Боловсролын эрх тэгш байдал нь үр дүнгийн тэгш байдал бус, боломжийг хүртэх тэгш байдлын тухай ойлголт юм.

Дээд боловсролын бодлого, эрх зүйн орчны жендэрийн дүн шинжилгээний үр дүнд тулгуурлан бодлого, эрх зүйн жендэрийн мэдрэмжийг нэмэгдүүлэх, эрэгтэй, эмэгтэй багш нарын эрх тэгш байдлыг хангахын тулд дараах өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай гэж үздэг.

Судалгааны хэсэг: Их сургуулийн төсвийн төлөвлөлтийн нөөцийн хуваарилалтын мэдрэмжийн нөхцөл байдал нөлөөлийн судалгаа шинжилгээ

Монгол улсын хувьд боловсролын салбар бол жендэрийн эрх тэгш байдал хамгийн өндөр үзүүлэлттэй байдаг салбар юм. Жендэрийн тэнцвэртэй бус байдлын индексийн хамгийн сүүлийн байдлаар Монгол улс дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн боловсрол эзэмших боломжийн индекс 0.995 байна (Дэлхийн Эдийн Засгийн форум 2013, 285). Азийн бусад улс орнуудаас ялгаатай нь Монгол улсад охид, эмэгтэйчүүд тэр дундаа насны хувьд харьцангуй том охид, эмэгтэйчүүд сургуульд сурах, боловсрол эзэмших нь түлхүү байдаг (Коломб баАлтанхуяг 2012). Жендэрийн дүн шинжилгээ нь зөвхөн тухайн салбарын хэмжээнд байгаа жендэрийн холбоотой саад, бэрхшээлийг тодорхойлоод зогсохгүй, нийгмийн хэм хэмжээ болон тухайн хүйсийн онцлогт хамаарах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, судлах боломжийг олгодог.

Төсвийн жендэрийн мэдрэмжийн дүн шинжилгээ. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь санхүүгийн нөөцийг илүү оновчтой, үр өгөөжтэй хуваарилах, зарцуулахад туслах замаар нийгэм, салбар, орон нутаг, байгууллагын өмнө тулгамдаж

буй жендэрийн аливаа асуудлыг шийдэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа юм. Төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийснээр төсвийн нөөцийн хуваарилалтын үр дагаврыг илрүүлэх, засч залруулах ач холбогдолтой.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн дүн шинжилгээний аргууд нь шийдвэр гаргагчдад бодлогын зорилгодоо хүрэхэд тулгардаг бэрхшээлүүдийг илрүүлэх боломж олгодог. ШУТИС, ДаТС-ийн төсвийн жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээг доорх судалгаанаас харж болно. Жендэрийн дүн шинжилгээг төсвийн орлого, зарлагын ангиллыг ашиглан боловсруулна.


Хүснэгт 1.

Орлогын дүн шинжилгээ /сая төгрөг/			
Хичээлийн жил	2015-2016	2016-2017	2017-2018
Нийт орлого	2.819.9	2.658.3	2.827.41
СТС	100.58	152.55	41.579
Лицейн санхүүжилт	41.06	36.59	
ТЗ	147.75	126.67	0
ДБШТ		12.0	9.8
Бакалавр өдөр	1.816.6	1.723.1	1.778.62
Бакалавр эчнээ	49.7	188.7	622.23
Магистр	125.8	51.2	289.90
Лицей	47.3	68.1	108.84
Оюутны байрнаас	63.5	45.8	42.33
Түр сургалт	8.1	0	12.04
Гэрээт ажил	0.7	0	38.66
Хандив ийн орлого	0.7	0	2.67
Харилцах дансны хүүгийн орлого	15.9	0	0
Оюутны үйлчилгээний орлого	35.3	10.5	5.18
Түрээсийн орлого	6.58	10.46	0
Бусад орлого	46.1	24.0	35.40

2018-2019 оны хичээлийн жилд 4157,9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн орлогын бүтцийг харахад 67.3%-ийг сургалтын төлбөрийн, сургалтын төрийн сангийн 1%, төвлөрсөн арга хэмжээний 28.8%, бусад орлогын 2.9%-г тус тус бүрдүүлсэн байна. Тус хичээлийн жилд бусад ажил үйлчилгээний орлого 133.6 сая төгрөгт



Зураг 1. Үйл ажиллагааны динамик



Зураг 2. Гарцын динамик



Зураг 3. Орцын динамик



Зураг 4. Нийт орцод үзүүлэх хувийн жин динамик

Дээрх графикуудаас харахад гарц, орцын үзүүлэлтүүд нь байнга өсөлттэй байгаа нь харагдаж байна.



Зураг 5. Нийт гарцад үзүүлэх хувийн жин динамик



Зураг 6. Нийт бүтээмж динамик



Зураг 7. Үндсэн нийт хүчин зүйлийн бүтээмж динамик



Зураг 8. Капиталын бүтээмж динамик



Зураг 9. Материалын бүтээмж динамик

БНСУ-ын КОЙКА олон улсын байгууллагатай хамтран 74 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг КОЙКА ОУБ-аас 3.1 сая төгрөгийг өөрийн сургуулиас гарган нийт 77.1 сая төгрөгөөр Компьютерийн нэгдсэн сургалтын төв 2, Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ ХК-ний хөрөнгө оруулалтаар 44.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 8.4 сая төгрөгний эргэлтийн хөрөнгө хүлээн авч “Цахилгаан тоноглолын лаборатори” хүлээн авсан. ТӨБЗГ-аас хэрэгжүүлсэн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ болон, эзэмшил газрын үнэлгээг амжилттай хийж, тайланд тусган хөрөнгийг нэмэгдүүлсэн ба эзэмшил газрыг 1.928.7 сая төгрөгөөр барилга байгууламжийг 7.088.2 сая төгрөгөөр дахин үнэллээ.



Зураг 10. Хөдөлмөрийн бүтээмж динамик

Хөдөлмөрийн бүтээмжийн динамикийн хувьд үйл ажиллагааны орлогоор тооцоолоход PL-2.28-2.89 буюу 1.04-1.60 хооронд хэлбэлзэж байна. Өсөлт бууралт нь 2016 буюу 2018 онд буурсан үзүүлэлттэй харагдаж байна. Энэ нь хөрөнгө оруулалт, лабораторийн тоног төхөөрөмжийн парк шинэчлэлт хийсэн, шаардлага хангаж байгаа эсэх асуудлууд нөлөөлж байна.



Зураг 11.. Нийт бүтээмж ба TPF динамик

Дүрслэлээс харахад нийт бүтээмж -0.18-0.01 буюу TPber 0.174-0.255 хооронд өсөлттэй харагдаж байна. Цаашид нийт бүтээмж ба ашгийн үзүүлэлтүүд буурах нь эрдэм шинжилгээ судалгааны ажлаас орох орлого, сургалтын төлбөрийн орлого зэрэг нь хүн ам зүйн бодлого, ЕБС-ын боловсролын системийн тогтолцооны алдаатай бодлого, техникийн боловсрол эзэмших боловсролын сонирхол буурч байгаа үзүүлэлтүүд ихээхэн нөлөөлж санхүүгийн тогтвортой ажиллагааны хувьд сөрөг үзүүлэлт харуулж байгаа хэдий ч их сургуулийн хувьд төсөвлөлтийн хэтийн төлөвлөлтийг бодьтой бус хийсвэр тооцоонд тулгуурлаж, профессор багш нараас санал асуулга, салбарын сургалт, эрдэм шинжилгээний ажлын зардлын санал авахгүй байгаатай холбоотой байна.

Их сургуулиудын санхүүгийн төсвийн төлөвлөлтийн жендэрийн мэдрэмжийн дүн шинжилгээ

Нийгмийн бодит байдалд (de facto) жендэрийн тэгш байдлыг тогтоох, ялгаварлан гадуурхалтыг

төслөн зогсоохын тулд жендэрийн зориудын арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Тус судалгааны хэсэг дээр бодлогын асуудлыг шийдэх хувилбар, шийдэлийг дараах хүчин зүйлсийг тодорхойлон шинжиллээ.Үүнд:

1. Бодлогын асуудлыг шийдэх хувилбар, шийдэл


2. Профессор багш нарын өөрийн үнэлгээний тайлангуудад шинжилгээ хийж үзлээ.

ДаТС-нь өөрийн эрхэм зорилго болон үйл ажиллагааныхаа зорилго зорилтуудыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах боловсон хүчин, хүний нөөцийг салбар, нэгж, хөтөлбөр бүрээр бүрдүүлэн ажиллахын зэрэгцээ тэдний хөгжлийг дэмжин ажиллаж ирсэн.



Зураг 12. Багшийн тоо хүйсээр

2018-2019 оны хичээлийн жилд тус сургууль үндсэн 86 багш, 58 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс: эмэгтэй 46 багш, эрэгтэй 28 багш ажиллаж байгаа нь жендэрийн тэгш байдал алдагдах магадлал 0.97 байгаа нь харагдаж байна. Мөн доктор (Ph.D)-20-ийн эмэгтэй 15, эрэгтэй 5 багш, профессор-2 эмэгтэй 1 багш, дэд профессор 3-аас 2 эмэгтэй багш, ахлах багш 26-аас 9 эрэгтэй, багш 49-өөс эмэгтэй 24 буюу 84%-нь, дадлагажигч багш 1 ажиллаж байгаа нь харагдаж байна.









Зураг 13. Багшийн насны ангилалаар

ДаТС-нь 2015-2021 он хүртэл баримтлах урт хугацааны стратегийн зорилт, үндсэн чиглэлийг тодорхойлж, түүнд хүрэх арга зам, хэрэгжүүлэх үйл ажиллагааг шаардагдах нөөц, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдэд нийцүүлэн сургалт эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа багш нарын хувьд 30 хүртэл насны багш эрэгтэй 2, эмэгтэй 1, 30-50 насны 66 багшаас 21 эрэгтэй, 44 эмэгтэй, 51-54 насны 5 багшаас эрэгтэй 4, эмэгтэй 1 багш, 55 настай багш нараас эмэгтэй 1, 56-59 насны багш нараас эрэгтэй 3 багш, 60 наснаас дээш эрэгтэй 1 багш ажиллаж байгаа нь жендэрийн эрх тэгш байдал алдагдах магадлал 0.99%-д хүрэх магадлал өндөр байгаа нь судалгаагаар нотлогдож байна. Тус сургууль хичээлийн жилд 156 илтгэл, өгүүлэлийг гадаадад дотоодод хэлэлцүүлсэнээс давтагдсан тоогоор эрэгтэй 17 буюу 23% багш, 22 эмэгтэй багш буюу 30% нь нийтлүүлсэн нь сургуулийн хэмжээнд нийт оролцооны 53% идэвхтэй оролцож байгаа нь харагдаж байна.


Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төсөвлөлт:

ШУТ-ийн сангийн 37.7 сая төгрөгийн санхүүжилт, 12.7 сая төгрөгийн суурь судалгааны төсөл хэрэгжүүлсэн нь 0.03% эрэгтэй багш оролцож хэрэгжүүлж байна. КОЙКА олон улсын хамтын ажиллагааны хүрээнд 79 сая төгрөгний буюу 0.4%-ийн эмэгтэй багш нар оролцсон байна. Дотоод түншлэлийн хамтын ажиллагааны хувьд Цахилгаан тоноглолын лабораторийг 57.8 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн буюу оролцооны хувьд эрэгтэй 11%, 0.05% буюу 4 эмэгтэй багш оролцсон нь судалгаанаас нотлогдож байна. Нийгэм эдийн засгийн судалгааны ажлын хувьд эрэгтэй 2 багш буюу 0,03%, эмэгтэй 2 буюу 0,03% жендэрийн тэгш оролцоотой оролцсон байна. Зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан багш нарын хувьд эрэгтэй 8 багш буюу 0,11%, эмэгтэй 3 багш буюу 0,41%-ийг тус тус эзэмшиж байна. Тус судалгаанаас бодлогын асуудлыг шийдэх хувилбар, шийдэлийг тодорхойлход ДаТС-ийн бодлогын тэнцвэрийг хангах дараах орчин, үйл ажиллагааны бодлогын шийдвэрүүдийг олон хувилбаруудыг тодорхойлж төлөвлөх нь зүйтэй гэж дүгнэж байна. Мөн цаашид сургалтын процесст оролцож буй багш нарын хувьд сургалт, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг жендэрийн үзэл баримтлалын бодлогод нийцүүлэн тусгах, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг төлөвлөх, хяналт шинжилгээ үнэлгээний асуудлыг нөөц баялагт тулгуурлан жендэрийн мэдрэмжтэй хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах нь зүйтэй гэдэг нь судалгаагаар нотлогдож байна. Жендэрийн ялгаатай үйл ажиллагаа, төсөвлөлтийг нэмэгдүүлэхэд үйл ажиллагааны үүргийн хувиарлалт, технологид тулгуурласан, ажиллах хүчинд тулгуурласан жендэрийн төсөвлөлтийг хийх нь зүйтэй гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.





Их сургуулиудын төсвийн төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх боломж, арга, зам



Зураг 14.

ДаТС-ийн төсвийн төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөх зөвлөмж.

Улс орны хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл бол улсын төсөв тул засгийн газар нийгэмд тулгамдсан хэрэгцээг өөрт байгаа хязгаарлагдмал нөөцтэй тэнцвэржүүлж, юунд хэдий хэмжээний хөрөнгө зарцуулах, санхүүжилтийг хэрхэн олж бүрдүүлэх арга замыг төсөвтөө тусгадаг. Иймд төсөв нь шийдвэр гаргагч, эрх баригчдын хариуцлагын баталгаа, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх арга зам болдог. Иймд тухайн хичээлийн жилд хуримтлуулж буй орлогыг зөв оновчтой хуваарилах, зарцуулах, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцлийг баланслуулах зөвлөмжийг тодорхойллоо.

1. Их сургуулиудын удирдлагын баг, хүний нөөцийн ажилтнууд, эдийн засагч, санхүүгийн ажилтнуудын жендэрийн мэдлэгийн боловсролыг нэмэгдүүлж боловсруулсан төсөв, цалин хөлс, үйлчилгээ хэлбэрээр очихдоо тэдэнд хэрхэн нөлөөлж буйг илрүүлж дүн шинжилгээ хийдэг байх.

2. Эрэгтэй, эмэгтэй профессор багш нарын хувьд тэгш нөлөөлөхөд төсөвт ямар хүчин зүйлс хязгаарлалт саад болж байгааг тодорхойлох шаардлагатай.

3. Төсвийн бодлого нь жендэрийн бодлоготой уялдан нийцэж буйг тодорхойлж хэлэлцэн баталж, үр дүнг бодитой болгох.

4. Дээрх 3 шатны зөвлөмжийн дагуу дүн шинжилгээ хийсний эцэст төсвийн хуваарилалт эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээнд нийцээгүй жендэрийн тэгш бус байдлыг хадгалах, гүнзгийрүүлэх нөлөөтэй төсөвт жендэрийн мэдрэмжтэй болгох үндэс суурь бүрэлдэнэ.

5. Нийгэм хат олонд тулгарч байгаа жендэрийн асуудлыг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хэрэгцээг хангахад төсвийн үйлэвч, хуваарилалт, зарцуулалт хэрхэн нөлөөлж байгааг тодруулах цаашид хэрхэн сайжруулах хэрэгцээг тодорхойлох зорилгоор төсөвт жендэрийн төсвийн төлөвлөлтийн тухай шинжлэн судалж, жилийн эцэсийн тайланд бодит байдалд нийцүүлэн үнэлэх.

6. Жендэрийг төсвийн хүрээний дүн шинжилгээний үндсэн үзүүлэлт болгон нэвтрүүлэх, төсөвт жендэрийн дүн шинжилгээг байнга хийлгэж хэвшүүлэхийн тулд чадавхи бэхжүүлэхээс гадна холбогдох эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай.

6.1. Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ хийх

6.2. Эрэгтэй, эмэгтэй профессор багш нарт тулгарч буй асуудал, жендэрийн ялгаварт байдлыг илрүүлэх

6.3. Жендэрийн тэгш байдлын зорилт, түүний биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох зэрэг төсөвлөлтийн үе шатны ажлуудыг эргэх холбоотойгоор оновчтой дүгнэх.

7. Жендэрийн мэдрэмжтэй нөлөөллийн үйл ажиллагаа (бодлогын өөрчлөлт, бодлогын эрх зүйн шинэчлэл, стратегийн нэгдмэл зорилго, хамтран хэрэгжүүлэх итгэл үнэмшил)-г зохион байгуулан, нөлөөллийн стратегийн төлөвлөгөөг боловсруулан ажиллах. (Лобби хийх, олон нийтийн хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах, гэгээрүүлэх сургалт зохион байгуулах, судалгаа явуулах)

Ашигласан ном

Монгол хэлээр:

[1] Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүн, тайлан (2012-2017).

[2] Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn

[3] Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам. Жилийн тайлан (2000-2017).

[4] Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Азийн хөглийн банк. “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”.

[5] Монго Улсын Засгийн газар. Монголын боловсролын 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө.

[6] Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг. “Боловсролын салбарын тойм судалгаа” 2013 он.

[7] Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Монгол Улсын “Боловсролын тухай”хууль, Монгол Улсын “Дээдболовсролын тухай”хууль.

[8] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт. “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2015, 2016, 2017, 2018”

[9] А.Заяадэлгэр.“Боловсролын эдийн засаг”, 2011 он.

[10] Т.Амаржаргалан. “Дээд боловсролын хөгжлийн хандлага, бодлого, чиглэл”Англи хэлээр:

[11] World bank. World development indicators

[12] OECD. Education indicators

[13] Nizamettin Koc, Bekir Celik“The impact of Number of Students per Teacher on Student Achievement”. Global Conference on Contemporary Issues in Education, 2014, Las Vegas, USA